

БААСАН ЛАМ

С.Отгонжаргал

Монгол Улсын Их Сургууль. Нийгмийн Шинжлэх Ухааны Сургууль. Түүхийн тэнхим

Өгүүллийн товч утга: 1990 оны ардчилсан шинэчлэлийг удирдалцаж явсан түүхт хүн, лам Д.Баасангийн амьдрал үйл ажиллагааг өөрийнх нь болон эхнэр Алтанцэцэгийнх нь дурсамж, архивын материалд тулгуурлан тодруулах зорилго тавьсан болно. Мөн түүхт хүн гэж зөвхөн насан туршдаа өндөр албан тушаалд заларч явсан хүмүүсийг хэлэхгүй, харин олон түмний оюун санаанд өөрчлөлт авчирсан буюу атаршсан тархинд өчүүхэн боловч хөдөлгөөн оруулж чадсан хүнийг хэлнэ гэдэгт өгүүллийн товч утга оршино.

Түлхүүр үг: түүхт хүн

1921 оны хувьсгалд монголын ард түмэн нэгдсэн нэг фронт болон нэгдэж харийн түрэмгийлэгчдийн эсрэг тэмцэхэд лам хуврага, хутагт хувилгаад гар хумхин суусангүй харин ч хамгийн идэвхитэй оролцсон нь түүхийн хуудаснаа тод үлджээ. Консулын бүлгэмийг анхлан санаачлагч нэр нөлөө бүхий лам Д.Бодоо, Д. Чагдаржав, Д. Лосол нар МАН-ыг үүсгэн байгуулалцсан юм. 1921 оны хувьсгалын дараа МАН-ыг МАХН болгож өөрчлөх их гүрний бодлого аажмаар хэрэгжиж, улмаар 1924 оны БНМАУ-ын Үндсэн хуульд монголын ард түмнийг эсрэг, тэсрэг эвлэршгүй хоёр анги болгон заав. Үндсэн хуулийн 33-р зүйлд “Аливаа хурлын төлөөлөгчдийг сонгох ба, мөн төлөөлөгчдөд сонгогдох эрхгүй хүмүүс нь: Нэг, ямагт ашгийг эрмэлзэж бусдыг зарж мөлжин амьдрагчид, хоёр, ямагт бусдыг хөлслөн зарах ба, хөрөнгө орлого зэргийн үржлээр амьдрагч жинхэнэ худалдааны ба мөнгөн хүүлэгчид, гурав, **урьдын ван, гүн ба, хутагт хувилгаад жич орон хийдэд үргэлж суух санваартан лам нар, ...**” (БНМАУ-ын Үндсэн хууль, Монгол Улсын 14 он, 32-р тал) хэмээн зааснаар монголын ард түмний хамгийн идэвхитэй сэхээрэлт нэгэн хэсэг нь ялангуяа хувьсгалын үйл явцад амь биеэ хайрлалгүй зүтгэж явсан лам хуврагууд төрд сонгогдох эрхээ алджээ. Монголын анхны Үндсэн хуульд харийн хүчирхийллийн сүүдэр тусах гэж буйг урьдчилан мэдэж монголын гэсэн Үндсэн хуулийг санаачлан боловсруулах гэж өөрийн хэрээр тэмцэж явсан Д.Бодоо, Д.Чагдаржав нар 1922 онд хилс хэргээр буудуулан амиа алдсан юм. Анхны Үндсэн хууль батлагдсанаас хойш Монголд шашны эсрэг тэмцэл улам эрчтэй өрнөж “1920-иод оны эцэс 1930-аад оны үед 100 гаруй шар феодал лам нарын хөрөнгийг хурааж ... хүрээ хийдийн 6000 гаруй жасын 3 сая гаруй мал, 60 гаруй сая төгрөгийн хөрөнгийг хураав. 1937 онд 1689, 1938 онд 15268, 1939 онд 47, нийт 17004 лам нарыг баривчилж, 13679 лам нарыг цаазаар авч, бусдыг нь шоронд хорьжээ... мөн 767 сүм хийдийн ихэнхийг нь эвдэн сүйтгэж зэс, гуулин бурхан зэрэг нийт 71,6 тонн эд зүйлсийг ЗХУ-д шилжүүлжээ. Ийнхүү Монголд шашингүй төр, шашингүй үзэл, ноёрхсоноор итгэл, сэтгэлээ тайвшруулах зүйлгүй болсон монголчуудын сэтгэлд хоосон орон зай үүсч ёс заншил, үндэснийхээ онцлогийг гэжж оросжих хандлага илрэх болсон юм. Түүхийн эрхээр бөөгийн шашнаас бурханы шашинд шилжсэн монголчуудын хувьд ёс заншил, өвөрмөц өнгө аяс бурханы шашинтай холбоотой байсныг үгүйсгэж болохгүй юм.” (С.Отгонжаргал. Монголын төр шашны харьцаа, мөн чанар “Шашин шүтэх, эс шүтэх эрх, эрх чөлөө” эмхэтгэлд УБ, 2004, 56-р тал) 1980-аад он болоход МАХН ард түмнийхээ шашин шүтэх эрхийн эсрэг Нийгмийг хамгаалах яамыг зохион байгуулалттай ажиллуулснаар шашин шүтэх эрх Монгол оронд бүрмөсөн хаагдаж, 700 гаруй сүм хийдээс үлдсэн бараг цорын ганц хийд болох Гандантэгчинлэн хийд ёс төдий хурал хурсан болж нэр зүүх

болжээ. Учир нь энэ ариун дагшин газар хэн дуртай нь очих эрхгүй, лам нар дотор нь ч НАХЯ-ны бууны ноход зүсээ хувирган сууж хийдэд ирж сэтгэлээ ариутгасан хэнийг боловч өчиггүй мэдээлдэг байв. Ажил амьдралгүй болохыг хэн хүсэх билээ. Гандантэгчинлэн хийдийн дэргэд Шашны дээд сургууль хэмээх том нэр зүүсэн цөөн тооны шавьтай бага хэмжээний сургууль ажиллаж байв. Энэ сургуульд сурах хүсэлтэй хүн цөөнгүй байсан боловч өнгөрсөн түүхийн хар мөрүүд балраагүй тул эцэг эхчүүд дийлэнхи тохиолдолд хүүхдүүдээ шавилан суухыг хориглодог байв. Гол төлөв томоохон лам нарын хүүхэд энэ сургуульд суралцдаг байсан хэдий ч хүсэлдээ хөтлөгдөн суралцах нь цөөнгүй байв. Ийм хүнд хэцүү үед Засагт хааны уугуул Дорлигжавын хүү Баасан энэ сургуулийн өндөр босгоор зоригтой алхан оржээ.

Дорлигжавын Баасан нь 1955 оны 9 дүгээр сарын 2-нд Улаанбаатар хотын 1-р амаржих газар эхээс мэндэлжээ. 1971-1973 онд ТТМС төгсөн УБ хотын 1-р авто баазад засварчнаар орж ажил амьдралынхаа гарааг эхэлсэн боловч түүний сэтгэл түүх болон үлдэхдээ тулсан шашныг сонирхож хязгааргүй хүсэлдээ автсанаар 1974 онд Гандан хийдийн Шашны дээд сургуульд шавилан суусан байна. Шашны сургуульд нэг жил номын дуу сонссоны дараа анх удаа гэр лүүгээ явахаар нийтийн унаанд суухаар хүлээн зогсох зуур тэнд холхилдож байсан хүмүүс түүнд дэндүү харанхуй мэт санагдаж "Яаж энэ хүмүүсийн мэлмийг нээж, шашны агуу их ухааныг ойлгуулах вэ" гэж сэтгэлдээ шаналаж байсан гэдэг. Арга ч үгүй биз "социализмын" гэгдэх жилүүдэд шашны байдал ямар байсныг түүний яриагаар тодруулья. "1970-аад онд Монголд тэсэж үлдсэн Гандантэгчинлэн хийд гаднаас нь харахад хэнд ч хамааралгүй мэт байсан хэдий ч НАХЯ-ны бүрэн эрхшээлд орсон байсныг шавилан суусан цагаас мэдэх болсон. Монголд 100-гаас дээш лам байж болохгүй, хурал номыг лам нар зөвхөн гэртээ, сүмдээ л уншина, ард иргэдэд шашныг сурталчилж болохгүй г.м хатуу хууль ноёрхож байв. Үхэл хагацал тохиож ойр дотныхоо хүнийг цаг бусаар алдаж, амьдрал нь утгаа алдсан цөөн тооны "иргэний зориг" гаргагсад, аливаа юмнаас айх нас нь хэтэрсэн хөгшчүүл л сэтгэлийн тайвшрал авах гэж сүмд ирдэг байсан юм. Гандан дээр ном уншуулахаар ирсэн хүн нэг бүр албан ажил, гэрийн хаягаа үнэн зөвөөр бүртгүүлэх ёстой. Бүртгүүлсний дараа НАХЯ-нд дараа нь МАХН-ын ТХ-нд шуурхай мэдээлэл болон очно. Шашны Дээд сургууль дээр томилолтоор хичээл заахаар ирсэн багш нар "2000 он гэхэд шашин устана, та нар тэр үед ажилгүй болно. Тэр цагт та нараас гайгүй нь музейн тайлбарлагч, номын санч л болно. Ирээдүй чинь ийм л байна. Монголын хөгшчүүл үхэж дуусахад шашин мөхөж шашингүй үзэл ноёрхох болно. Тэр үед Монголд коммунизм тогтоно. Тийм учраас эм, зурхай, нарийн увьдасыг сурах гэж цаг алдах хэрэггүй гэх мэтээр сурталчлах нь ердийн зүйл байж дээ. МУИС-ийн залуу багш нар ч ингэж л хичээлээ заана. Өвгөн лам нар болохоор яаж шашнаа устгуулчихгүй авч үлдэх талаар ярина. Та нар минь л шийдэнэ дээ гэх мэтээр ярина. Гэтэл лам байж байгаад хар болчихсон хөгшчүүл буюу том лам нар нууцаар цугларч ном хурна, одоо бодоход хамгийн хориотой байсан Нар хажидын чойгийг олноороо уншина. Энэ ном нь амар амгалан авчрах, зовлонгоос ангижруулах зорилготой ном шүү дээ. Хориод байх шалтгаангүй мэт." Ийн оюуны мэлмийгээ өөрийн уншсан, үзсэн хэмжээгээр нээсэн түүнд энгийн эгэл хүмүүс харанхуй мэт харагдах нь арга ч үгүй биз. Тэрээр 1979 онд сургуулиа төгсөж Гандантэгчинлэн хийддээ хурлын голч ламаар ажиллаж байхдаа 1985-1987 онд Улаан Үдийн багшийн дээд сургуулийн хэлний курсэд суралцаж төгсөөд эргээд хийддээ голч ламаар 1989 он хүртэл ажиллажээ.

Тэрээр С.Зоригтой оюутан байхад нь буюу Москвад сурч байхад нь танилцжээ. Тэд уулзах бүрдээ улс төрийн сэдвээр л голчлон ярилцдаг байв.

Шашнаа сэргээх, монгол ёс заншил, төр шашны харьцааны уламжлалыг эргүүлэн тогтоох боломж байгаа эсэх талаар бодон шаналаж явсан Баасан С.Зоригтой нөхөрлөснөөр түүний үзэл бодолд нилээдгүй өөрчлөлт оржээ. Шашнаа шашин шиг авч явахын тулд улс төрөөр оролдох хэрэгтэй гэсэн шинэ бодол түүнд төрсөн аж. Харамсалтай нь ярьж суудаг хүн нь шашингүй үзэлтэйн дээр МУИС-д шинжлэх ухаан коммунизмын онолыг заадаг байсан нь бэрхшээлтэй байсан хэдий ч Монгол оронд ардчилал тогтвол шашинг хавчихгүй гэдэгт тэрээр дотроо итгэдэг байв. Гэвч яаж гэдэг асуудал бас л зовоосоор. Монгол Улсыг өөрчлөх талаар байнга ярилцаж суухдаа тэд тухайн үедээ эсэргүү маягийн юм ярьдаг байснаа ухаарч байсан ч ярихаас өөр зам байсангүй. Тэднийг ардчилсан нийгэм байгуулах хүсэл нь л нэгтгэж байв.

Баасан лам ханьтайгаа оюутан байхдаа учирчээ. Азтай нь эхнэр Алтанцэцэг нь тэдний ярианаас маш их айж эмээдэг байсан хэдий ч сэтгэлийнхээ мухарт дэмждэг байсан нь түүнд урам хайрладаг байв. Үг хэлэх эрх чөлөөтэй нийгэмд амьдрах юмсан гэж мөрөөддөг эхнэрийнх нь хүсэл түүнийг улс төрийн замд эргэлт буцалтгүй ороход нь ч нөлөөлсөн байж болох. "Хэдийгээр ийм маягийн нийгэм нь капиталист нийгэм гэж мэдэж байсан хэдий ч ийм л нийгмийг би хүсэж байсан учраас нөхрийгөө дотроо дэмжиж байсан юм" гэж эхнэр Алтанцэцэгийн хэлсэн үг үүнийг гэрчлэнэ. Д.Алтанцэцэг нь эмэгтэйчүүдийн эмч, мэрэгшлээрээ бол охидын эмч. 1984 онд Намын дээд сургуулийг төгсч, улс төрийн дээд боловсрол эзэмшсэнийхээ хувьд нөхрийнхөө ярианд үг үсэг нэмэрлэдэг нэгэн байсан аж. Тэгээд ч тэрээр Түшээт хан аймгийн мэргэн гүн Лодой бэйсийн ач охины хувьд ламын ёс жаягийг сайн мэддэг, лам хүнийг хүндэлдэг байсан учраас лам нарын хэлмэгдлийг, 1990-ээд оны лам нарын байдлыг сайтар ойлгодгийнхоо хувьд ханиа ойлгож дэмжиж байжээ. Алтанцэцэг Баасан ламтай анх танилцаж байхдаа түүнийг лам хүн гэж мэдэлгүй түүний хүлээцтэй даруу занд нь татагдсан гэдэг.

1989 оны 8 дугаар сарын 2-ноос 10 сар гартал Гандан хийдийн томилолтоор ЗХУ, Монгол, Болгар, Швейцар, Англи гэсэн таван улсын "Энх тайвны элч Рейрихийн замаар" гэсэн олон улсын аялалын хэсэгт орж Оросын Горный Алтайгаар явжээ. 10 дугаар сард Улаан Үдээр дамжиж ирэхэд Бакула Ринбүчи багш Монголд элчин сайдаар томилогдон ирсэн байв. Шашны хүн төрийг төлөөлөн ирсэн нь Баасан ламд нэгийг бодогдуулжээ.

1989 оны 11 дүгээр сард телевиз үзэж суутал залуу уран бүтээлчдийн улсын 2 дугаар зөвлөгөөнийг шууд нэвтрүүлж байсныг ихэд сонирхон үзжээ. Үг зөвлөгөөнд оролцож байсан залуучуудын өөрчлөн байгуулалтыг эх орондоо түргэн хурдацтай явуулах талаархи яриа түүний сэтгэлд хүрсэн байна. 11 пүгээр сарын сүүлээр 10-р хороололд тэрээр таньдаг айлдаа сууж байтал "Үнэн" сонины сурвалжлагч Ж.Лхагваа орж ирээд "залуучууд хөдлөх нь байна шүү" гэсэн нь түүнд улам их эрч хүчийг өгчээ. Баасан лам тэр даруйдаа С.Зоригтой уулзая гэж шийдээд маргааш нь хурлаа дуусмагц Зориг руу шууд утасджээ.

С.Зориг: - залуучууд үнэхээрийн хөдлөх гэж байна. Би хэсэг залуучуудтай уулзлаа. Бидний яриа ч нийлж байх шиг байна. Маргааш эмнэлэг гэгээрлийн ордон дээр оройн 6 цагт уулзалт болно. Гэхдээ байрлалаа жаахан нууцлаад байх шиг байна, хоёулаа ямар ч байсан очье" гэжээ.

Маргааш нь Баасан лам эмнэлэг гэгээрлийн ордны хурлын зааланд ганцаараа очтол хэн ч байсангүй. Байрлалаа сольсон нь тодорхой байв. Тэрээр шууд Зоригийн гэрт очоод түүнийг хүлээж байтал Зориг орж ирээд:

- Байрлалаа сольсон байна, би ч бас очоод ирлээ. Маргаашнаас дахин холбоо барьцгаая гэжээ. Ингээд тэд улс төрийн үйл явцад бэлэн байх талаар ярилцаж тохироод салцгаажээ. Маргааш нь хурлаа тараад Баасан лам Зориг

руу ярьтал:

- Нөгөөдрийн маргааш (1989 оны 12 дугаар сарын 9. С.О) Бямба гаригийн 3 цагт чухал уулзалт болно. Чи Залуучуудын соёлын төвийн дугуй зааланд хүрээд ир, нөгөө улсуудтайгаа тэнд уулзацгаая гэжээ.

Баасан лам 1989 оны 12 дугаар сарын 9-ний Бямба гаригт дугуй зааланд хүрээд очтол заал дүүрэн хүн сууж байжээ. Тэрээр энэ өдрийн тухай: - Тэр олон хүнийг хараад би үнэхээрийн их гайхсан. Смольныйд хувьсгалын өмнө яг ийм байсан болов уу хэмээн бодогдсон. Тэгтэл олон хүн дотроос Баасан! хэмээн дуудахаар нь хартал уран барималч Хайнзангийн Цэгмид байв. Түүнтэй ярьж суутал С.Зориг орж ирсэн. Заалны голд зассан ширээг тойроод Ц.Элбэгдорж, Э.Бат-Үүл, Б.Билэгт, С.Амарсанаа, Г.Бошигт нар сууж байлаа. Гаднаас Д.Нинж 400 төгрөгний пальтотой малигар өндөр цагаан залуу орж ирсэн. Нүдэнд их содон байсан. Тэгтэл үүдэнд тэнд тэн д г арч гүйсэн гялтаган асан цоглог нэг нөхөр харагдсан. Энэ бол Малыш Энхтүвшин байв. Цугларсан хүмүүс 12 дугаар сарын 10 бол хүний эрхийн өдөр, энэ өдөр анхныхаа жагсаалыг хийцгээе гэж шийдээд түүнд бэлдэж уриа, лозунг бичиж байтал Бат-Үүлийн аав Төрийн шагналт, зохиолч С.Эрдэнээ гуай орж ирээд:

- Та бүхнийг дэмжиж байна гэж хэлсэн хэмээн ярьсан юм. (Баасан ламын 1989 оны 12 дугаар сарын 9-ний өдрийн тухай ярьсныг засваргүйгээр орууллаа. С.О)

Баасан ламын энэхүү дурсамж он цаг явах тусам улам үнэ цэнэтэй болох нь эргэлзээгүй юм. Гэхдээ Баасан лам зарим нэгэн болсон явдлыг тухайн үедээ орхигдуулсан байсныг энд тодруулах нь зүйтэй болов уу. МЗЭ-ийн хорооны санаачлагаар залуу уран бүтээлчдийн II зөвлөлгөөн 1989 оны 11 сард болов. "Уран барималчдаас сонгогдсон залуус өөрчлөн байгуулалтыг үргэлжлүүлэхэд үйл ажиллагаагаа чиглүүлэх, залуу уран бүтээлчдийн эвсэл байгуулахыг зөвлөлгөөнд оролцогчдод уриалахаар тохиролцжээ. Зөвлөлгөөн эхлэхийн өмнө ...нэг өдрийг чөлөөт ярилцлагын өдөр болгосон нь санаа нийлсэн хүмүүст бие биенээ таних боломж олгожээ. Монументаль чимэглэлийн үйлдвэрийн барималч Болд, Цэгмид, Монгол кино студийн ажилтан Нарантуяа, найруулагч Жумдаан, УБДС-ийн оюутан Дарь. Сүхбаатар ...нар санал нэгджээ." \ М.Энхээ МоАХ МоАН УБ. 1991 х. 6\ Эдгээр хэсэг залуус С.Зоригийг урьж ярилцсан нь цаашид тэдний үйл ажиллагаа МУИС дээр төвлөрөх эхлэлийг тавьжээ. Гэхдээ тэд тооны хувьд цөөхөн байгаагаа мэдэрч хэрхэн яаж хүрээгээ тэлэх вэ гэдэгт анхаарлаа хандуулж байсан учраас энд тэнд болох нууц хурал цуглаанд ихээхэн ач холбогдол өгөх нь гарцаагүй юм. Баасан ламын дээр дурссан чухал үйл явдлын өмнөхөн буюу 1989 оны 12 дугаар сарын 7-ны орой МУИС-ийн хичээлийн II байрны 252 тоот өрөөнд хэсэг залуус тангараг өргөсөн байдаг. Тангаргын эхийг Дарь. Сүхбаатар зохиож бусад нь зарим нэгэн засвар хийснээр **Тангараг** бэлэн болжээ. Тангаргын эхийг Дарь.Сүхбаатар уншиж бусад нь даган хэлж, Зүрхэн тушаагаа гараа тавьцгаан 13-уул тангараг өргөцгөөжээ. С.Амарсанаа, Д.Баасан, Э.Бат-Үүл, Б.Билэгт, Г.Бошигт, С.Зориг, Д.Нинж, Л.Нямсүрэн, Д.Сосорбарам, Дарь.Сүхбаатар, Ц.Элбэгдорж, Д.Энхбаатар, Б.Энхтүвшин гэсэн ардчиллын анхны 13 хэмээн түүхнээ үлдсэн эдгээр залуучууд улс эх орныхоо төлөө эцсээ хүртэл тэмцэхээ 1921 оны хувьсгалчдын нэгэн адил амь насаараа дэнчин тавин тангаргалсан байна. Тангараг өргөсний дараа тангаргынхаа эх бичгийг **Сундуйн жүд** (Нууцын хураангуй С.О) гэдэг том номны хураангуй болох жижигхэн шоголтой номны завсар хийж, Баасан ламд хадгалуулжээ. 12 дугаар сарын 9-ний өдөр Баасан лам заал дүүрэн хүмүүс цугларсаныг хараад ихэд гайхаж байсныг бодоход эдгээр тангараг өргөсөн залуустай нэгэн адил залуус энд тэнд бүлгэм дугуйлан маягаар үйл ажиллагаагаа явуулж байгаад бие биенээ таньж мэдсэний үр дүнд

эвлэлдэн зохион байгуулагдсан бололтой.

1989 оны 12 дугаар сарын 10-ны өдөр буюу олон улсын хүний эрхийн өдөр хийсэн анхны цуглаан тэдний тооцож байснаас илүү амжилт авчрах нь тэр. Цуглаанд олон зуун хүн сайн дуураараа оролцож Ардчилсан Холбоог чин сэтгэлээсээ дэмжин, цаашид уг холбоонд нэгдэн нийлэх саналаа хэний ч шахалтгүйгээр илэрхийлсэн нь залуучуудад урам өгч дараагийнхаа жагсаал цуглааныг Сүхбаатарын талбайд хийхээр "том" дуугарав. Гэтэл Сүхбаатарын талбайд жагсаал хийх нь хориотой болохыг "дээрээс" сануулж хатуу арга хэмжээ авахыг ч анхааруулав. Хэвлэл мэдээллийн хэрэгсэл бүгд хаалттай байсан болохоор залуучууд жагсаалаа яаж хийхээ ярилцжээ. Цуглаан хийх газраа солихоор хүн ирэхгүй нь тодорхой. Энэ бол хаалттай нийгмийн онцлог. Талбайд цуглаан хийхээр өчиггүй баривчлагдах нь коммунист нийгмийн жишиг. Бүгд яах вэ гэж ярилцах хооронд Баасан ламд нэгэн мэргэн санаа орж иржээ. Тэрээр энэ тухай дурсахдаа "Бид жагсаалаа хийхийн тулд янз янзын л санаа оноо дэвшүүлж байлаа. Гарцаа хайж маргалдаж суухдаа бүгд л дор бүрнээ бухимдацгааж байв. Би ч бусдын адил Яах вэ? гэж тархиа гашилгаж суулаа. Гэнэт надад хүүхэд байхдаа сонсож байсан "Цэцэн бэрийн үлгэр" санаанд минь орж ирсэн юм. Тэр үлгэрт нэгэн хаан тэнэг хүүдээ ухаантай хатан авч өгөх гэж ядуу өвгөний охиныг олон удаа шалгаж байгаа тухай өгүүлдэг. Охин ч хааны даалгаврыг амжилттай давж байтал нэгэн өдөр хаан өвгөн дээр ирээд "Чи маргааш намайг ирэхэд ганц охино о гадаа ч биш гэрт ч биш байлгаж байгаарай. Гэрт гадаа хоёрын аль нэгэнд байлгавал чамайг шийтгэнэ" гэжээ. Хааны хэлсэн гадаа ч биш гэрт ч биш гэсэн энэ үгнээс жагсаалаа хаана хийх санаа олсон юм. Тэгээд би "Сүхбаатарын талбайд ч биш өөр газар ч биш газар хийцгээе. Дуурь бүжгийн театрын урд талын талбай бол Сүхбаатарын талбай биш гэхдээ жагсахаар ирсэн хүмүүст энэ талбай тод харагдана гэж саналаа хэллээ. Нөхдүүд маань миний энэ саналыг дэмжиж жагсаалаа миний санал болгосон газар хийсэн юм. Ямар ч л байсан бид аливаа бэрхшээлийг олуул хэлэлцэн шийдэж мянга мянган дэмжигчдийнхээ итгэл сэтгэлийг алдалгүй авч явсны нэг жишээ энэ юм" гэж билээ. Түүхийн хүрдийг эргүүлэхэд олон хүний оюун санаа, оюун ухаан шавхагдаж байж зөв гольдрол руу нь оруулдгийн нэг жишээ энэ болов уу.

Ийнхүү 1989 онд Монголд ардчиллын хөдөлгөөнийг үүсгэлцсэн Баасан лам МоАХ-ын тэргүүлэгчээр 1991 он хүртэл сонгогдон ажиллажээ. Тэрээр Буддын гүн ухааны гэвш цолтой байсан аж. 1989 оны 12 дугаар сарын 9-ний өдрөөс хойш Баасан ламын ардчилагчид үе үе цугларч хийх ажлаа төлөвлөн ярилцдаг болжээ. Монгол дахь ардчилсан хөдөлгөөнийг үүсгэн байгуулагч, олонд танигдсан нэгэн байсан хэдий ч тэрээр шагнал бус зэмлэл хүлээж байсан удаатай. Хэрэв Бодоо лам Монгол улсаа тусгаар улс шиг байлгахын төлөөнөөс тэмцэж байгуулалцсан намаасаа хөөгдөж байсан бол Баасан лам, Нэргүй доктор, Бошигт хоёрын үзэл бодлын зөрөлдөөнийг өөрийн байр сууринаас дүгнэж үзэл бодлоо илэрхийлснийхээ төлөө МоАХ-ны тэргүүлэгч гэсэн тухайн үедээ нэр хүнд бүхий суудлаас хөөгдөж байжээ. Түүний ярьснаар тэрээр хэт зүүний үзэлтэй гэгддэг Нэргүйгээс зайгаа барьж, Бошигтыг дэмжсэн аж. Яагаад? Шууд хариулт өгөхөд хэцүү ч Нэргүй докторыг дэмжвэл олон хүн Ард түмний онц зөвлөлөөр орох гээд байдаг. Энгийнчлээд харвал 1921 оны хэлмэгдэлт давтагдах гээд байгаа юм шиг сэтгэгдэл Баасан ламд төржээ. Гэтэл С.Зориг Нэргүй докторт хир халдаахгүй талд нь байгаад байдаг. Энэ үеэс С.Зоригийг ара й ө өр өнц гөөс дүгнэх болжээ. Түүний онолын мэдлэг дутуу санагдаж, бие сэтгэлээрээ шууд дагах нь учир дутагдалтай мэт бодогдох болжээ. Тэгээд ч дээрээс нь "но" тоочвол эх түүх, монгол бичгээ мэдэхгүй, мэдэх шаардлагагүй гэж үзнэ, шашингүй үзэлтнийхээ хувьд Баасан ламын амь

биеэ огоорон их үйлсэд хөл тавьсаны утга учрыг тэрээр дутуу үнэлжээ. Энэ бүгдийн улмаас Баасан лам МоАХ-нд олон ургальч үзэл, урсгал байх нь зүй ёсны үзэгдэл хэмээсэн Бошигтын үзлийг дэмжжээ. Гэтэл С.Зориг ихэд бухимдаж “Дуртай юм бол энэ байгууллагаас гарч, өөр байгууллагаа байгуул” гэснээр Баасан ламыг хэсэг хүмүүсийн хамт МоАХ, МоАН дахь сонгуульт албан тушаалаас нь огцруулжээ. Удаа ч үгүй С.Зориг өөрөө Нэргүй доктороос зайгаа барьсан аж. 1990 оны 6 дугаар сарын 2-нд МоАХ-ны ЕЗЗ-ийн хурал хуралдаж Баасан лам урьд өмнөх суудалдаа эргэн очжээ.

Монгол оронд төр, шашны харьцааг сэргээх, монголчуудад шүтэх эрхийг нь эргүүлэн олгох хүсэл нь түүнийг ардчилсан хувьсгалд эргэлт буцалтгүй оруулсан юм. Тэрээр адлагдаж шоодогдсон шашны төлөөллийн хувьд Монголын ардчилсан намд гишүүнээр элсэхдээ сэтгэлийн угтаа тээж явсан мөрөөдлөө л биелүүлэх чин зорилготой байв. Түүнд Далай лам тусалсан тухай тэрээр дурсахдаа “Анхны цуглааны үеэр буюу 1989 оны 12 дугаар сарын эхээр манай хийдийн их хамба Гаадамба Энэтхэгийн нэгэн их сургуулийн хүндэт доктор болохоор Энэтхэг явсан юм. Гэтэл Энэтхэгийн ТВ-ээр Монголд 12-р сарын 10-ны өдөр цуглаан болсон тухай тодорхой мэдээ сонсоод хамба маань ихэд цочирдсон гэдэг. Удирдлага доорхи лам нь жагсаад явж байхад хариуцлага хүлээх нь тодорхой. Монгол дахь шашны нөхцөл байдал ямар байсныг хэнээр ч хэлүүлэлтгүй мэдэхийнхээ хувьд тэрээр Далай ламд бараалхахдаа миний тухай сэтгэл түгшин асуусан байдаг. “Жагсаал цуглаанд миний лам оролцсон байна ийм тохиолдолд яах ёстой вэ?” гэжээ. Далай багш: “Би бас харсан. Дэлхий нийтийн хувьд байж болох үзэгдэл. Танайд бол өөр байх. Гэхдээ түүний дотоод сэтгэл, бодол санаа нь юунд байна гэдэг нь чухал. Хүний хоморгонд ороод явж байна уу, уг хүн ямар хүн юм бэ, хэрэв тэр хүн зөв бодол санаатай хүн бол дэмжих хэрэгтэй” гэсэн хариулт өгчээ. Гаадамба хамба энэ хариултыг сонсоод нилээд тайвширсан гэдэг. Энэ утгаараа Далай багш намайг дэмжсэн байдаг юм. МоАН-аар шашнаа дэмжүүлж, хэлмэгдэж үрэгдсэн хутагт хувилгаад, лам хуврагынхаа нэр төрийг сэргээх л хүсэлтэй байснаас албан тушаал ашиг хонжоог урьдал болгоогүй намайг дээрхийн гэгээнтэн ийнхүү мэдэж дэмжсэнд нь одоо ч баярлаж явдаг юм” гэж билээ. Баасан лам Монголын сүсэгтний холбоог үүсгэн байгуулснаар санаа нь амарсангүй. Гандантэгчинлэн хийдийн бие даасан байдлыг сэргээж монголын бурхны шашинтны төв болгох, монголын лам хуврага сүм хийдийн тэргүүн нарын чуулга уулзалтыг зохион байгуулах, төр шашныг хослуулах уламжлалт бодлогыг хэрэгжүүлэх, IX Богд гэгээн Жамбал Намдол Чойжий Жанцанг Монголын Бурхны шашны тэргүүнээр өргөмжлөх, түүнийг Монгол Улсын иргэн болгох асуудлыг шийдүүлэх зэрэг хийх ажил дэндүү их байлаа. Далай лам түүнийг дотоод сэтгэл ноён нуруутай нь тольдсон нь түүнд сэтгэлийн их эрч хүчийг өгсөн байна.

Баасан ламыг жагсаал цуглаанд оролцсоноос нь болж эхнэр Алтанцэцэг нь нилээд хүнд б эрхийг т уулсан аж. Түүнийг хотын намын хорооноос өдөр болгон дуудаж ажлыг нь шалган өө сэв хайхын зэрэгцээ бүхий л шагнал урамшууллаас хасдаг байв. Гэсэн ч тэрээр шантарсангүй нөхрийгөө жагсаал цуглаанд явахыг нь хориглож байсангүй харин ч байнга дэмжиж байжээ. Түүгээр ч зогсохгүй хоёр хүүхдээ гэртээ цоожлоод бүхий л жагсаал цуглаан, хурал зөвлөгөөнд нь хамт явдаг байв. Түүнд тохиолдсон нэгэн инээдтэй явдлыг тэрээр хожим дурсан ярихдаа: - Жагсаал цуглаан болж байх үед их эмч байсан намайг Толгойтын зүүн салаанд асрагч болгон ажиллуулж бүхий л муу муухайг би тэнд үзэж явлаа. Тэгтэл жагсагчид ялалт байгуулсны дараа манай клиникийн эмнэлгийн хамт олны хурал болж намайг клиникийн даргаар ажиллахыг санал болгосон. Би клиникийн даргын ажлыг аваагүй. Би хүний хоол

булааж идэх гэж ажил хийгээгүй, миний нөхөр ч үүний төлөөнөөс жагсаал цуглаанд оролцоогүй гэдгийг хэлсэн. Ийм л инээдтэй нийгэм байлаа шүү дээ. Тухайн үед нөхрөө хүмүүжүүлж чадаагүй гэж намын хурлаар хүртэл орж байлаа. Намын хурал гэдэг бол шүүх хурал шиг л эрх мэдэлтэй байсан шүү дээ. Гэр бүлийн асуудал ч намын хурлаар шийдэгддэг байсан. Намын дээд сургууль төгссөн болхоор намайг хүчээр МАХН-ын идэвхтэн гишүүн хэмээн үзэж ийнхүү намын хурлаар шийтгэж байсан гэж билээ. Тэрээр ханийхаа талаар дурсахдаа: "Баасан бол нийгмийн захиалгаар төрсөн хүн, их ч бодь хүн. Бодь хүн гэж агуу их ухаантай, уужуу хүнийг хэлнэ. Гэтэл одоо бодь хүн гэхээр тэнэг маанаг хүн гэж ойлгодог болжээ. Нөхрөө дээдлэн шүтсэн энэ эмэгтэй ханийгаа холын зайнаас буудчих болов уу, хаа нэгэн газар алаад хаячих болов уу гэж байнга санаа зовж үргэлж дагаж явдаг байжээ."

Өдгөө охин нь аялал жуулчлалын менежментийн мэргэжилтэй, хүү нь шашны чиглэлээр Энэтхэгт суралцаж байгаа аж.

Алтанцэцэгийн хувьд 1990 оны 3-р сарын 7-8 ны өдрүүд хамгийн хүнд өдрүүд байжээ. 1990 оны 3-р сарын 4-нд Ардчилсан хүчнүүд АИХ-ыг тарааж Ардын түр Хурлыг байгуулах, Ард түмний онц зөвлөлийг байгуулах хугацааг товлохыг шаардаж хамтарсан мэдэгдэл гаргажээ. Хариуг 3-р сарын 7-ны 12 цагаас өмнө өгөхийг шаардсан боловч хариу өгсөнгүй. Ийм тохиолдолд хэрхэх тухайгаа хэлэлцэж байтал Э.Бат-Үүл өлсгөлөн зарлах санаачлага гаргаж, МоАХ-ны зохицуулах зөвлөл хэлэлцэж дэмжсэнээр 1990 оны 3-р сарын 7-ны 14 цагт Э.Бат-Үүл, Б.Батцэнгэл, Б.Билэгт, Г.Бошигт, Б.Галсандорж, Д.Дорлигжав, И.Жавхлант, Д.Нинж, З.Эрдэнэбат, Д.Энхбаатар зэрэг 10 хүн өлсгөлөн зарлав. 3-р сарын 9-н болоход өлсөгчид 24 болж нэмэгдэв. 3-р сарын 8-нд Д.Содном, Д.Бямбасүрэн нар Засгийн газрыг төлөөлж МоАХ-ны төлөөлөгчидтэй уулзсан хэдий ч өлсгөлөн зарлаж байсан Э.Бат-Үүл МАХН-ын ТХ-ны Улс төрийн товчоог бүрэн бүрэлдэхүүнээрээ огцрох шинэ шаардлагыг нэмж тавив. Тухайн үедээ уг шаардлага нь парадокс байсан гэдэгтэй хэн ч маргахгүй бизээ. Уулзалт амжилтгүй болов. Гэтэл МАХН-ын Төв Хорооны УТТ-ны 2 гишүүн Улаанбаатар хотод онц байдал тогтоох, эмх замбараагүй байдал үүсвэл зэвсэг хэрэглэх эрх олгох тогтоолын төсөл оруулж ирэв. Энэ мэдээ Сүхбаатарын талбайгаар зогссонгүй орон даяар гэрлийн хурдаар тарав. Монгол хүн болгон элэг эмтрэн шаналж байсан үе. Энэ үед Баасан лам эхнэртээ "Биднийг баривчлах шийдвэр гарвал Баасан лам намайг эрт хаяад явсан гэж хэлээд хоёр хүүхдээ л амьд авч гарахыг бодоорой" гэж захиж байжээ. "Энэ үеийг бодоход одоо ч хүнд санагддаг. Ж.Батмөнх гуайн алсыг харсан уужуу тайвуу ухаан бидний хувь заяаг аварсан даа" гэж хэлэхдээ тэр үед очсон мэт нулимс нь цийлэгнэж билээ.

1989 онд зүүн Европоос эхэлсэн ардчилал өөрчлөн байгуулалтын салхи Монгол оронд нөлөөлж Монголын түүхэнд урьд хожид үзэгдээгүй жагсаал цуглаан өрнөж Монгол орныг донсолгож байх үед жагсагчдын дунд нэгэн содон хувцастай жагсаал алгасалгүй хамгийн идэвхитэй оролцож явсан хүн бол Дорлигжавын Баасан байсан юм. МАХН хэвлэл мэдээллийн бүхий л хэрэгслээр жагсагч залуучуудыг гудамжны лүүмпэнгүүд, ажилгүйчүүд хэмээн сурталчилж байсан тухайн үед Баасан ламыг харсан хэнд боловч яавч энэ залуучууд муу хүмүүс биш гэсэн эерэг сэтгэгдэл төрж байсныг тэмдэглэх хэрэгтэй. Монголын ард түмэн шашингүй үзлээр олон арван жил нүдүүлсэн хэдий ч сэтгэлийнхээ угт шашнаа дээдэлж ирсэний нэгээхэн илрэл нь энэ байлаа. Олон мянган жагсагчдын дунд лам дээл өмссөн зоримог маягийн залуу бусдаас онцгойрон харагдаж байсан нь учиртайв. Цор ганцаар эр зориг гарган ардчилагчидтай нэгдсэн энэ ламыг 1922 онд лам Д.Бодоо, Д.Чагдаржав нарыг буудан алсан шиг баривчилсан бол Монголын ард түмэн тэр чигээрээ

босно гэдгийг МАХН-ын эрх баригчид мэдэж байсан бизээ. Нээрээ ч ХХ зууны сүүлч үеийн сэхээрэлт монголчууд түүхийн хар мөр давтагдахыг тэвчихгүй байсан биз. Энэ ч утгаараа Баасан лам бүхний хайрыг татсан нэгэн байв. Лам нарыг төлөөлөн жагсаж байсан Д.Баасан олон арван залуучуудад зориг, зүрх өгч гудамжны жагсаалд "уруу татан" гаргасан нь ч түүхэн үнэн. Лам хуварга ч Хүн учраас өөрсдийнхөө төлөө улс төрийн тэмцэл хийж болно гэсэн замыг нээж өгснөөрөө олон арван лам нар, залуучуудын тархин дахь атаршлыг арилгаж томоохон хөдөлгөөнд оруулснаараа тэрээр түүхт хүн юм.

Abstract: This article aims to review the life and activities of the historical personality, priest D.Baasan, one of the co-leaders of the 1990 democratic reforms referring to his and his wife Altantsetseg's recollections and archival materials. Also the author tried to provide the definition of a historical personality as a man who managed to make changes in people's minds or to introduce even slight movements to the virgin minds of the people but not those who forever stayed in high positions.

Ашигласан ном зохиол

1. БНМАУ-ын Үндсэн хууль, Монгол Улсын 14 он.32-р тал
2. С.Отгонжаргал. Монголын төр шашны харьцаа, мөн чанар "Шашин шүтэх, эс шүтэх эрх, эрх чөлөө" эмхэтгэлд УБ., 2004. 56-р тал
3. Ч.Энхээ. МоАХ МоАН УБ. 1991 х. 6